



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ



Хэрэгжүүлэгч :

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих (ICED) төсөл

Улирал тутмын мэдээллийн товхимол
№ 3/2024

2024


Гадаад худалдаа
эрхлэгчдэд зориулсан
гарын авлага



ICED ТӨСӨЛ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГАЗРЫН АЗИ ДАХ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИН АЖИЛЛАЖ БАЙНА

Хөрөнгө оруулалт, худалдааны газар (ХОХГ)-ын төлөөлөгчид БНХАУ-ын Харбин хотын Олон улсын худалдааг дэмжих зөвлөлд 2024 оны 6-р сарын 20-23-ны өдрүүдэд зочиллоо. ХОХГ-ын дарга В.Энхбаатар, БНХАУ-ын Олон улсын худалдааг дэмжих зөвлөлийн дэд дарга, Хэйлунжан мужийн Олон улсын экспогийн хөгжил, сурталчилгааны төвийн ерөнхий захирал Тан Байчэнг нар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.

Санамж бичгийн хүрээнд хоёр орны хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны төслүүдийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцжээ.



Монгол улс, БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны (ӨМӨЗО) худалдаа хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны дөрөв дэх удаагийн форум 2024 оны 8-р сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа. ӨМӨЗО-ны худалдаа бизнес эрхлэгчдэд зориулан “Монгол улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин” сэдэвт танилцуулга, сургалтыг 8 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулав. Энэхүү сургалтаар ХХОГ-ын мэргэжилтнүүд Монгол улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль, эрх зүйн зохицуулалт, гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал, нэг цэгийн үйлчилгээний талаар танилцуулав.



**ICED ТӨСӨЛ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГАЗРЫН АЗИ
ДАХ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИН АЖИЛЛАЖ БАЙНА**



ХОХГ болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг (KOTRA) нь худалдаа, эдийн засгийн салбарт хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, худалдааг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичигт 2024 оны 4-р сард Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан юм. Санамж бичигт тохиролцсоны дагуу ХХОГ-ын мэргэжилтнүүд 2024 оны 9-р сарын 24-ны өдөр KOTRA-д зочилж, нэг цэгийн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын дараах үйлчилгээ, гомдол маргааныг шийдвэрлэх талаар харилцан туршлага солилцов.



ГАДААД ХУДАЛДАА ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛАВ

Гадаад худалдааг ашигтай, амжилттай эрхлэхийн тулд бараа бүтээгдэхүүнийг хоёр болон түүнээс дээш улс оронд худалдан борлуулах, импортлох тухай хууль тогтоомжийг сайтар ойлгох нь бизнес эрхлэгчдэд хөрөнгө болон цагийг хэмнэх чухал ач холбогдолтой юм. Иймд ХОХГ-ын захиалгаар “Гадаад худалдаа эрхлэгчдэд зориулсан гарын авлага”-ыг боловсруулав.



Энэхүү гарын авлагын нэгдүгээр бүлэгт олон улсын худалдаа, түүнд оролцогч талууд, экспорт, импортын барааны гаалийн татвар, Монгол Улсын нэгдэн орсон бүс нутгийн болон бусад чөлөөт худалдааны хэлэлцээрийн хүрээнд эдлэх хөнгөлөлттэй тарифуудыг, хоёрдугаар бүлэгт гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар, гуравдугаар бүлэгт импортын замын зураглал, гаалийн бүрдүүлэлтийн талаар, дөрөвдүгээр бүлэгт экспорт, хөнгөлөлтийн ерөнхий систем, экспортын замын зураглал, гаалийн бүрдүүлэлтийн талаар тусгасан байна.

Мөн гарын авлагын хавсралт хэсгээс Европын холбооны хөнгөлөлтийн ерөнхий систем GSP+-д хамрагдах бараа, Монгол-Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АРТА)-ийн дагуу хөнгөлөлттэй тариф бүхий экспорт, импортын барааны жагсаалтыг харах боломжтой юм.

ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ СУДАЛГАА ХИЙГДЛЭЭ

Үндэсний томоохон компаниуд олон улсад худалдаа арилжаанд идэвхитэй оролцох болсоноор манай оронд худалдаа эрхлэгчдийн эрх зүйн хамгааллыг бэхжүүлэх шаардлага бий болж байна. Иймээс худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн акт, бичиг баримт, статистик мэдээллийг нэгтгэн дүгнэх замаар өнөөгийн худалдааны эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох судалгааг хийж гүйцэтгэв.



Энэхүү судалгаагаар олон улсын худалдааны зохицуулалтад төрийн байгууллагын болон бусад оролцогч талуудын үүрэг, оролцоо, Монгол улсын нэгдсэн олон улсын гэрээ хэлэлцээр, стратегийн түнш орнуудтай байгуулсан Чөлөөт худалдааны хэлэлцээрийн талаар судалж төрөөс худалдааны салбарт баримталж буй бодлого, салбар хуулиудын зохицуулалтуудыг нэгтгэн дүгнэж, худалдааны эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудлыг тодорхойлоо.

Мөн Бүгд Найрамдах Чех улс, Холбооны Бүгд Найрамдах Герман улсын худалдааны бодлого, хууль, эрх зүйн орчныг харьцуулан судлав. Худалдааны салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжид дүн шинжилгээ хийснээр худалдааны салбарын үйл ажиллагааг зохицуулах хуулийн зохицуулалтын талаар зөвлөмж боловсрууллаа.

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР ЭХЛЭВ

2024 оны 3-5-р сард хийгдсэн ICED төслийн суурь судалгааны үр дүнд үндэслэн жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг 4 үндсэн багцтай байхаар боловсруулсан юм. ЖДҮ эрхлэгчдийн экспортын ур чадварыг дээшлүүлэх зорилготой сургалт, зөвлөх үйлчилгээний энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөхүүдийг 2024 оны 8-р сарын эцсээр сонгон шалгарууллаа:

- Багц 1: Санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, үйлдвэрлэлийн, чанарын менежментийг төлөвлөлт- “КапФин” ХХК
- Багц 2: Брэнд хөгжүүлэлт, маркетингийн стратеги, зах зээлийн шинжилгээ–“Эган брэнд консалтинг” ХХК
- Багц 3: Борлуулалт, борлуулалтын стратеги, аргачлал, хэлэлцээр хийх ур чадвар –“Содура Консалтинг” ХХК
- Багц 4: Жижиг, дунд бизнесийн холбогдох эрх зүй, гэрээ, гэрээний эрх зүй.



ТӨСЛИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗОХИЦУУЛАХ УУЛЗАЛТ БОЛЛОО

ЖДҮ-ийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулах, оновчтой зохион байгуулах зорилгоор 2024 оны 8-р сарын 7-9-ний өдрүүдэд “Зохицуулах уулзалт” зохион байгууллаа. Уулзалтанд чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээт зөвлөх компаниуд, зөвлөхүүд, Германы Шпаркассе сангийн Монгол дах салбарын төлөөлөл, Нийслэлийн ЖДҮҮ-г дэмжих төв (ICED-ийн түнш), ХХБ-ны төлөөлөгчид (тогтвортой санхүүжилтийн дэмжих SFME төслийн хамтран санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч) оролцсон юм.

Тус уулзалтаар Улаанбаатар хотын сонгогдсон ЖДҮ эрхлэгчид болон ХХБ-ны ажилтнуудад сургалт зөвлөх үйлчилгээг хүргэх, зөвлөх үйлчилгээний байгууллагуудын хамтын ажиллагаа, хоорондын уялдаа, зохион байгуулалт, чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг, хариуцлага, оруулах хувь нэмэр зэрэг олон асуудлыг хэлэлцэв.

УЛААНБААТАР ХОТЫН ЖДҮ ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭХЛЭВ

Улаанбаатар хотын ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөх үйлчилгээ 2024 оны 9-р сарын 9-ний өдрөөс эхэллээ. ICED төслийн гэрээт зөвлөх компаниуд, зөвлөхүүд санхүүжилтийн төсөл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах, борлуулалтаа нэмэгдүүлэх арга, аргачлал, брэнд бүтээгдэхүүнийг бий болгон хөгжүүлэх, хэлэлцээ хийх ур чадвар, гэрээ байгуулах зэрэг сургалт зөвлөх үйлчилгээний сэдвүүдээ танилцууллаа.

Улаанбаатар хотын ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөх үйлчилгээнд бизнесийн төрөл бүрийн салбарын 60 гаруй бизнес эрхлэгчид бүртгүүлсэн ба сургалт зөвлөх үйлчилгээ нь хоёр бүлгээр зохион байгуулагдаж байна. Энэхүү ЖДҮ-ийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр нь ICED төсөл болон Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих төвийн хамтын санаачилга бөгөөд төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөн дэх арга хэмжээнүүдийн нэг юм.



“АЖИЛ ХЭРЭГЧ УЛААНБААТАР” ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

Манай орны жижиг дунд бизнес эрхлэгчдийн 70 хувь нь (40 гаруй мянган аж ахуйн нэгж) нийслэл хотод үйл ажиллагаа явуулж, 600 гаруй мянган хүнийг ажлын байраар хангаж байна. Мөн тус салбарын нэг онцлог нь нийт жижиг, дунд бизнесийн 70 хувийг эмэгтэйчүүд удирдаж байна. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварын сайжруулах, экспортын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилго бүхий “Ажил хэрэгч Улаанбаатар” арга хэмжээг Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих төвөөс ICED төслийн дэмжлэгтэйгээр 2024 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр зохион байгууллаа.

Хангарьд ордонд 7.30-13.00 хооронд зохион байгуулсан тус арга хэмжээнд 200 орчим бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, нийслэлийн удирдлагууд оролцож тэдэнд тулгарч буй асуудал, бэрхшээл, бизнесийн орчны талаар ярилцаж, хамгийн чухал нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг Улаанбаатар хотын Захиргааанаас дэмжих боломжуудын талаар хамтран хэлэлцэв.


Мөн энэ өдөр үдээс хойш Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих төвийн 9 дүүргийн 100 орчим мэргэжилтнүүд уулзаж, тус төвөөс ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй үйлчилгээний үр дүнг сайжруулах, төрөлжүүлэн хөгжүүлэх арга зам, дэмжлэгийн олон төрлийн хувилбаруудыг хэлэлцлээ.



ХҮНСНИЙ НОГООНЫ КЛАСТЕР ХӨГЖҮҮЛЭХ САНААЧИЛГЫГ ДЭМЖИНЭ




Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих төвөөс хүнсний ногоо үйлдвэрлэгч жижиг дунд бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, тэдний орлогыг нэмэгдүүлэх, хүнсний ногоо тариалахад шинэ инновац, технологи нэвтрүүлэх зорилгоор Хүнсний ногоочдын кластерийг байгуулах санаачилга гарган ажиллаж байна. Энэхүү санаачилга нь Монгол Улсын Засгийн газрын импортын бараа бүтээгдэхүүнийг орлох бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний аюулгүй байдлыг хангах” хөтөлбөртэй бүрэн нийцэж байгаа юм.



Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих төв нь Хүнсний ногооны тус кластерийг Улаанбаатар хотын Ар Гүнтэд 40 га талбайг хамруулан байгуулах боломжийг ICED төсөлтэй хамтран судлана. Энэ судалгааны ажлыг 2024 оны 10-12-р сард хийхээр төлөвлөж, ICED төслийн зүгээс хүнсний ногооны кластерийн ТЭЗҮ-г боловсруулахад шаардлагатай бол кластерийн ирээдүйн гишүүд болох ногоочдыг чадавхжуулах зэргээр дэмжин ажиллах юм.

“ЖДҮ-ИЙГ ЧИГЛЭСЭН ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ” ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ХУРАЛ БОЛОВ



Монгол дах GIZ нь төр хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн хэд хэдэн төслийг хэрэгжүүлж байна. Үүний нэг нь Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ), Худалдаа хөгжлийн банкны хамтран санхүүжүүлж буй “Тогтвортой санхүүжилтийг дэмжих” (SFME) төсөл юм.

2024 оны 8-р сарын 22-28-ны өдрүүдэд GIZ-ийн Герман дах төвөөс Монгол, Хятад дах ТХХТ-ийн төслүүдийг хариуцагч ноён Валентин Коссак (Valentin Kossak) Монгол улсад ажиллав. Ноён Валентин Коссак төслийн баг, хамтран санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч түншүүдтэй уулзаж, ТХХТ-ийн төслүүдийн хэрэгжилт, үр дүн, саад бэрхшээл, ололт амжилтуудтай танилцав. Мөн GIZ болон ХХБ-ны хамтран санхүүжүүлж хэрэгжүүлж буй SFME төслийн удирдах хорооны хуралд Монгол, Хятад дах ТХХТ-ийн төслүүдийг хариуцагч ноён Валентин Коссак оролцов. Удирдах хорооны хурлаар SFME төслийн хэрэгжилтийн стратеги, хүлээгдэж буй үр дүн, үйл ажиллагааны төлөвлөгөөг дахин баталгаажуулж, хамтын ажиллагаа, төслийн хэрэгжилтийн хэлбэр, арга барил, мөн Удирдах хорооны ажиллах зарчим, дүрмийг хэлэлцэн тохиролцов.

“ГЕРМАНЫ ӨДӨР-2024” НЬ МОНГОЛЫН ЖИГИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭГ ОНЦОЛЛОО



Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ) болон Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тэмдэглэж, Чингисийн талбайд “Германы өдөр-2024” 9-р сарын 20-нд зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээнд ХБНГУ-тай хамтран үйл ажиллагаа явуулдаг олон аж ахуйн нэгж, боловсролын байгууллага, хөгжлийн төсөл хөтөлбөрүүд өөрсдийн үйл ажиллагаа, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг танилцуулав.

“Германы өдөр-2024” үеэр нийслэлийн ЖДҮ-ийг Дэмжих Төвийн Инноваци, төсөл хариуцсан хэлтсийн дарга М.Мөнхжаргал нь Монголын ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр GIZ-ийн PROGRES, ICED төслүүдтэй хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээ, ололт амжилтыг танилцууллаа. Энэхүү танилцуулгыг олон нийтийн сүлжээгээр шууд дамжуулсан ба та бичлэгийг дараах холбоосоор үзэх боломжтой (1:02:00-с эхэлнэ):



GIZ-ээс түгээж буй мэдлэг, туршлага нь Монгол улсын эдийн засгийг төрөлжүүлэх, ЖДҮ-г хөгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлж байгааг ноён М.Мөнхжаргал илтгэлдээ онцоллоо. Тэрээр Нийслэлийн ЖДҮ-г Дэмжих төвийг төлөөлж, ЖДҮ-ийг дэмжих, чадавхийг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж буй GIZ-д талархал илэрхийллээ.

Нийслэлийн ЖДҮ-г Дэмжих төвөөс М.Мөнхжаргалын илтгэл олон нийтэд хүрч, Нийслэлийн ЖДҮ-ийг дэмжих төв, ICED-тэй хамтран хэрэгжүүлж буй сургалт, зөвлөх үйлчилгээний хөтөлбөрүүдэд оролцох хүсэлт жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд өсөж буйг мэдэллээ.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ (SFME) ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАХ УУЛЗАЛТ



GIZ, ХХБ-тай хамтран тогтвортой санхүүжилтийг дэмжих (SFME) төслийн хэрэгжилтийн зохицуулалт, төлөвлөлтийн зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 9-р сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Тус уулзалтад ХХБ-ны 8 бүсийн захирлууд, ХХБ-ны төвийн удирдах ажилтнууд, GIZ төслийн баг, зөвлөх үйлчилгээний байгууллагууд, зөвлөхүүд оролцож, ХХБ-ны ажилтан, банкны харилцагч ЖДҮ-д чиглэсэн сургалт, зөвлөх үйлчилгээний талаар хэлэлцсэн. Оролцогч талууд төслөөс зохион байгуулахаар төлөвлөсөн сургалт, зөвлөх үйлчилгээний хөтөлбөр нь зөвхөн ЖДҮ эрхлэгчид төдийгүй банкны ажилтнуудад “өндөр эрэлттэй” гэж тодорхойллоо.



Түүнчлэн, оролцогчид сургалтын хөтөлбөрийн үр өгөөжийг дээшлүүлэх, онол дадлагыг хослуулах, чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд олж авсан мэдлэг мэдээллийг банкны бусад ажилтнууд, бусад банк, олон нийтэд хэрхэн түгээх тухай олон саналуудыг дэвшүүлж GIZ SFME -ийн төслийн баг үйл ажиллагаандаа тусгахаар шийдвэрлэсэн. Энэхүү уулзалт үр дүнтэй, найрсаг уур амьсгалд болж, түншүүд харилцан итгэлцэж хамтран ажиллах бэлэн байгаагаа илэрхийллээ.

ЖДҮ ЭРХЛЭГЧДИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН АНХНЫ ТӨГСӨГЧДӨД ГЭРЧИЛГЭЭ ГАРДУУЛАВ



Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн анхны сургалт, зөвлөх үйлчилгээнд бүрэн хамрагдаж, амжилттай төгссөн Улаанбаатар хотын 30 ЖДҮ эрхлэгчид 9-р сарын 26-ны өдөр гэрчилгээгээ гардан авлаа.

Мөн энэ өдөр сургалт зөвлөх үйлчилгээнд хамрагдсан бизнес эрхлэгчид “Алдар” гутлын үйлдвэр болон “Соёмбот оргил” ХХК-ийн маскны үйлдвэртэй танилцлаа. Эдгээр үйлдвэрүүдтэй танилцах явцдаа сурсан зүйлсээ баталгаажуулах, цаашид бүтээгдэхүүнээ хөгжүүлэх, хамтран ажиллах талаар хэлэлцэв.

ЖДҮ эрхлэгчдийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд ICED төслөөс бизнесийн ахиц дэвшлийг хүлээж байгаа бөгөөд хөтөлбөрийн эхний төгсөгчдийнхөө цаашдын бизнест амжилт хүсье.

ЭЗХЯ АЛБАН ХААГЧИД АВСТРИ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ СУРГАЛТАД ОРОЛЦЛОО



ЭЗХЯ-ны Бүс нутаг, орон нутгийн хөгжлийн газрын дарга тэргүүтэй мэргэжилтнүүд, Нийслэлийн ЖДҮ-ийг дэмжих төвийн төлөөлөл 7-р сарын 13-20-ны хооронд ЮНИДО-оос Австри улсад зохион байгуулсан туршлага солилцох сургалтад оролцлоо.



Энэхүү сургалтаар ЮНИДО-гийн бүс, орон нутаг хэрэгжиж буй үйл ажиллагааны чиглэл, амжилттай хэрэгжиж буй төслүүдийн талаар оролцогчдод танилцуулж, цаашид хамтран ажиллах боломжийг судлах зорилготой байв. Мөн уг туршлага судлах аялал нь бүс, орон нутгийн кластерийн хөгжил, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, бүс нутгийн өрсөлдөх чадвар, дэд бүтцийн чанартай үйлчилгээ, аж үйлдвэр, хүнс, мах, байгаль орчин зэрэг хөдөө аж ахуйн салбарыг дэмжих цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд оролцогчдыг чадавхжуулахад чиглэв.

ЮНИДО-оос Монгол Улсад хэрэгжүүлэх хөтөлбөртэй танилцсаны дараа кластерын хөгжлийн бодлогыг хөтөлбөрт тусгахаар тохиролцсон нь аяллын гол үр дүнгийн нэг байлаа. Оролцогчид Монгол Улсад жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой техникийн туслалцааны төслүүдийг хамтран судалж хэрэгжүүлэх талаар ярилцаж, санал солилцлоо. Туршлага солилцох сургалтад оролцогчид олон салбарын бодлогын санаачилга, стратеги, арга барил, үйлчилгээ нь бүс нутаг, салбар, кластер, аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, улмаар аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийг хангах, ялангуяа хөдөө аж ахуйн салбар, түүнчлэн олон улсын түншүүдийн олон талт худалдааны харилцаанд хэрхэн цогцоор нь хувь нэмэр оруулж болох талаар шинэ мэдлэг олж авлаа.

ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОН ТАЛТ ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ (ICED) ТӨСӨЛ



Нийтэлсэн: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг (GIZ)

Огноо: 2024 оны 10-р сар

Дизайн/Зураг: GIZ ICED төсөл

Холбоо барих: Г. Бүдханд
“Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих”
төсөл
3-р давхар, 38-р байр, Нэгдсэн Үндэстний
гудамж, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 210646, Монгол улс

Утас: (+976) 77117704
И-мэйл: gurtsog.budkhand@giz.de
Веб: www.giz.de/mongolia